

ГЛОБАЛЧЛАЛЫН ЭРИНИЙ МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ӨНӨӨГИЙН ДҮР ТӨРХ

*Ц.Баатар**

Монгол улс ардчилал зах зээлийн эдийн засгийг сонгож авсан тэр цагаас хойш өдгөө нэгэн арваныг ардаа орхиод одоо хоёр дахь арвандаа ороод явж байна. Өнгөрсөн хугацаанд шинэ либерализмын сонгодог жор болох өмчийн олон хэлбэрт шилжих, зах зээлийг өөрийнх нь жам ёсны гольдролд оруулах чиглэлд чамгүй амжилт олсон билээ.

Гэсэн хэдий ч захиргаадалтын нүсэр системийг халж чөлөөт зах зээлийн тогтолцоонд шилжих шилжилтийн явц тийм ч амар хялбар байгаагүй юм.

Ман ай улс хөрш ОХУ, шинээр тусгаар тогтносон Төв Азийн / Казак, Киркиз, Узбек, Тажик, Туркмен/ зах зээлийн эдийн засагтай орнуудын дотроос өмч хувьчлал, бусад олон үзүүлэлтээр түрүүлж яваа ч гэсэн өмч хувьчлалыг хэт яаравчилснаас ялангуяа мал аж ахуй газар тариалангийн салбарт зарим сөрөг үр дагавар гарч хөдөө аж ахуйн хөгжлийн бодлого алдагдсан тал бий.

Бусад салбарт ч зарим сөрөг үр дагавар гарсан юм. Алдсанаа залруулж ололтоо бататгаж, эдийн засгаа улам бүр нээлттэй чөлөөтэй болгох чиглэлээр явж байгаа нь глобалчлалын эриний Монголын эдийн засгийн өнөөгийн нэгэн дүр зураг гэж хэлж болох юм.

Монголын эдийн засагт зөвхөн өнгөрсөн 2002 онд гарсан өөрчлөлтийн талаар энд зухас авч үзье.

Өмнөх онтой харьцуулахад 2002 онд аж үйлдвэрийн салбарийн нийт гаргалт бага зэрэг буурчээ. /-0,3%/ Аж үйлдвэрийн салбарын үр дүн тааруу байсан нь уул уурхайн салбарын гаргалт 12,6%, цахилгаан дулаан усан хангамжийн салбарын гаргалт 4,0% тус тус багассантай холбоотой. Харин боловсруулах салбарын гаргалт 18,9% нэмэгдсэн байна. Ачаа тээвэрлэлт өссөн бол төмөр замаар зорчсон зорчигчдын тоо буурч, харин агаарын тээврээр зорчигчдын тоо өөрчлөгдсөнгүй. 2001 оны эхэнтэй харьцуулахад нийт малын тоо толгой 9% багассан буюу 2,4 сая толгой малаар хорогдсон нь 2002 он мал аж ахуйн хувьд тааруу жил болсныг харуулж байна. 2002 оны зудад хонь, тэмээ, хамгийн их нэрвэгдсэн бол ямааны тоо толгойн

*Ц.Баатар - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

хорогдол хамгийн бага байв. Нийт эдийн засгийн өсөлт хүлээгдэж буй гүйцэтгэлээр 2002 онд 3,0% орчим байх тооцоо гарсан байна.¹

Жилийн инфляци 2001 онд 8,3% байснаа 3% хүрч буурчээ. Инфляци буурахад хүнсний үнийн инфляци доогуур байсан нь гол нөлөө үзүүлсэн бол орон сууд /түлш/ цахилгааны үнэ нэмэгдсэн нь үнийн өсөлтийг эерэг төвшинд байлгасан байна.

Төгрөгийн ам.доллар, юаньтай харьцах ханш аажмаар суларсан хэвээр байсан ч оны 2 дахь хагаст ханшны сулралт хурдасчээ. 2001 онд төгрөгийн вон, евротой харьцах ханш чанаржсан бол 2002 онд өөрчлөлтийн чиглэл нь өөрчлөгдөж төгрөгийн ханш суларчээ. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 2001 онд 28% байсан бол 2002 онд 43% хүрч түргэсжээ. М2-ийн өсөлтөд хугацаат болон гадаад валютын хадгалмжийн өсөлт голлох үүрэг гүйцэтгэжээ.

Банкны системийн гадаад цэвэр актив 40% өссөн бол /үүний дийлэнх нь Төв банканд ногдож байгаа/ дотоодын цэвэр зээл 55% нэмэгджээ. Зээлийн нэрлэсэн хүүгийн төвшин бага зэрэг буурч, харин бодит хүүгийн төвшин 2001 онтой харьцуулахад өссөн дүнтэй байна. Төсвийн зарлага илүүтэй нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхэд хүрч энэ нь 2001 онд ДНБ-ий 36,3%, урсгал зардал 31,7%, нийт зардал 41,7% -тай тус тус тэнцэх болов. Худалдаа хөгжлийн банкны хувьчлалын орлого нь төсвийн орлогоос давсан зарлагыг нөхөхөд жинтэй нэмэр болж байна.

Экспорт буурч /-3,9%/, импорт нэмэгдсэнээр /3,3%/ худалдааны алдагдал 158 ам долларт хүрч ДНБ-ий 14%-тай тэнцжээ. /2001 онд 11%/ Экспортын зүйл ангиудаас эрдэс бүтээгдэхүүн, ноолуурын экспорт хамгийн ихээр буурсан бол алтны экспорт 58% болж өсчээ. Импортын хувьд нэхмэл бүтээгдэхүүн, хүнс, машин, тоног төхөөрмжийн импортын өсөлтийг бүрдүүлсэн гол зүйл ангиуд байв. 2002 онд УИХ-аас “Газрын тухай” хуулиар иргэдэд газар өмчлүүлэх эрхтэй боллоо. Өнгөрсөн онд болсон монголд хандивлагчдийн 9-р уулзалтад 44 улс, 17 олон улсын байгууллагын нийт 500 гаруй зочид төлөөлөгчид оролцов. Донор орнууд, олон улсын байгууллагууд нийтдээ 30 сая ам. Долларын тусламж үзүүлэхээр болов. 1990 оноос хойш өнөөг хүртэл Монголд 70 гаруй орны 800 сая гаруй ам. Долларын хөрөнгө оруулалттай, 2400 гаруй гадаадын шууд хөрөнгө оруулалттай компани үйл ажиллагаа явуулж байна. Тэдгээрийн 68% нь хамтарсан, 32% нь 100 хувийн гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд юм. Гадаадын хөрөнгө оруулалттай компаниудыг бүтцээр нь авч үзвэл уул

уурхайн салбарт 26%, хөнгөн аж үйлвэрийн салбарт 12%, мал аж ахуй түүхий эд боловсруулах салбарт 7%, их барилгын салбарт 7%, нийтийн хоол үйлчилгээний салбарт 5%, банк санхүүгийн салбарт 4%, бусад салбар 39%-ийг тус тус эзэлж байна. 1996-1999 онд Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын санхүүгийн байгууллагын зүгээс банкны салбарын шинэчлэлд зориулан олгосон тусламж, төслийн зээл, санхүүгийн салбарт хийсэн судалгаа, авсан арга хэмжээний үр дүнд өнөөдөр банкны систем харьцангуй тогтворжиж өрсөлдөөн нэмэгдэж байна. Арилжааны томоохон банкуудыг хувьчилах ажил явагдаж байна. Өнгөрсөн онд Монголын хамгийн том арилжааны банк болох Худалдаа Хөгжлийн Банкны (ХХБ) төрийн өмчийн 76%-ийг Швейцарын “Банка Коммерсиалле Лугано” болон АНУ-ын “Жералд Металс “ консерциумд 12,23 сая ам.доллараар хувьчиллаа. Хувьчлагдсан ХХБ-ны менежментийг Нидерландын “ING” группээс хийхээр боллоо. Энэ нь Монголын банкны салбарт шинэ үйлчилгээ, шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэхэд тус болно гэж үзэж байна.

Монголын хоёр дахь том банк болох 100% төрийн өмчид байсан Хөдөө аж ахуйн /ХААН/ банк энэ оны нэгдүгээр сарын сүүлчээр хувьчлагдлаа. ХААН банкыг Японы “Эйч Эс Секюритийз” компанид 6,8 сая ам.доллараар хувьчиллаа. Үлдэж буй хадгаламж банкнийг хувьчлах асуудал яригдаж эхэллээ.

Банкны салбарын хувьчлал нь эцсийн бүлэгт банкны үйл ажиллагаанд төрийн оролцоо, нөлөөллийг багасгахад чиглэж байгаа билээ. Өнөөдөр манай улсад 16 арилжааны банк, 70 орчим банк бус санхүүгийн байгууллага, 140 гаруй хадгаламж зээлийн хоршоо, 850 гаруй ломбард ажиллаж байна.

Өнгөрсөн оноос зарим банкууд интернэт банк, бэлэн бус төлбөр тооцооны дэвшилтэд хэлбэр болох Master болон Visa картыг үйлчилгээнд нэвтрүүллээ. Одоо манайд энэ төрлийн үйлчилгээ тогтмолжиж хамрах хүрээ, хэрэглэгчдийн тоо нэмэгдэж байна. Энэ бүхэн нь макро эдийн засгийн орчин тогтворжиход эерэг нөлөө үзүүлсэн хүчин зүйлүүд болж байна. Нөгөө талаар тодорхой эрхэлсэн бизнестэй тогтмол орлогын эх үүсвэртэй, барьцаа хөрөнгө бүхий зээлдэгчид бий болсны нэгэн илрэл гэж хэлж болох юм.

Монголд арилжааны банкуудын үйл ажиллагаа хэвийн болж, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоод олширч бэлэн мөнгөний нөөц тодорхой хэмжээгээр нэмэгдсэн нь зээлийн хүү буурах таатай нөхцлийг бүрдүүлж байна. Манай улсын санхүүгийн зах

зээлд гадаадын хөрөнгө оруулалт орж ирж эхэллээ. Тухайлбал Их Британий Виржинийн Арлуудад бүртгэлтэй Оросын “Миллинеум Секьюритиз Менежмент” компани монголд банк бус санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Тэдний зээл гол төлөв томоохон хөрөнгө оруулалтанд чиглэж байна. Зээлийн хүү нь Монголд хамгийн бага буюу жилийн 12-14 хувийн хүүтэй байна.

Гэсэн хэдий ч манайд зээлийн хүү өндөр хэвээр байна. Зээлийн үлдэгдлийг өмчлөгчөөр нь авч үзвэл хувийн салбарт олгосон зээл нийт зээлийн үлдэгдлийн 84,4 хувь, улсын салбарт олгосон зээл 4,6 хувийг тус тус эзэлж байна.

Сүүлийн жилүүдэд хадгаламж нилээд өсөх магадлалтай байна. Энэ нь макро эдийн засгийн тогтворжилт, банкнаас гадуурхи мөнгө эргэж банкинд орох болсон, гадаадаас ирэх хувийн гуйвуулга, банкуудын хадгаламжийн хүүний өрсөлдөөн, хадгаламжийн шинэ бүтээгдэхүүн банк бус санхүүгийн байгууллагын /ББСБ/ өсөлт зэрэгтэй холбоотой.

Ялангуяа манай улсын иргэд БНСУ, АНУ, Герман, Их Британи, Япон зэрэг орнуудад янз бүрийн шугмаар ажиллах болсноор иргэдийн хувийн гуйвуулга ихээхэн нэмэгдэж байна. Гуйвуулгын нийт хэмжээ жилд орж ирж буй гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээнээс 2-3 дахин их байна. Энэ нь хадгаламжинд нөлөөлөөд зогсохгүй ханшийг тогтворжуулахад нөлөөлж буй гол хүчин зүйлийн нэг болж байна. Өмнөд Солонгос, Америк зэрэг орнуудад Хятадын Чайна Таун /China Down/ шиг жижигхэн Монгол таун бий болж байна. Үүнийг ардчилал, глобалчлалын нэгэн эерэг үр дагавар гэж хэлж болно.

Санхүүгийн хөрөнгө оруулалт Монгол улсад орж ирэхэд хамгийн таатай хууль эрх зүйн орчинг бүрдүүлээд байгаа хэдий ч үнэт цаас, хөрөнгийн зах зээл нялхаараа байна. Түүнчлэн санхүүгийн глобалчлалын эринд гадаадын валютын чөлөөт урсгалыг зохицуулах бодлого өнөө хэр алга байна. Нэг үгээр хэлбэл, Азийн валют санхүүгийн хямралаас сургамж аваагүй гэсэн үг.

Бэлчээрийн мал аж ахуйн хөгжил ч бүрхэг хэвээр байна. Эрчимжсэн мал аж ахуйд шилжүүлэх нь зүйтэй гэж дээр дооргүй ярьж байгаа хэдий ч түүнийг шийдэх арга замаа олоогүй байна. Асар хурдтай хувьсан өөрчлөгдөж байгаа байгаль, экологи Монголын бэлчээрийн мал аж ахуйд түгшүүрийн харанга дэлдэж байна. Ямар ч байсан урьдынхаараа явж болохгүй нь тодорхой боллоо.

Монгол орны эдийн засгийн өнөөгийн төрх иймэрхүү байна. Энэ байдлыг дэлхийн улс орнуудтай харьцуулан судласан гадаадын судлаачдын судалгааны дүнтэй харьцуулан үзвэл бүр ч сонирхолтой дүр зураг харагдана. Учир нь бид өөрсдийн орчин, үнэлэмжиндээ хэт дассан улс.

АНУ-ын “Жэй И Остин АссошиэТС” /JAA/ компани Монгол улсын түүхэнд анх удаа өрсөлдөх чадварын судалгааг гаргасан байна. JAA компани Виржини мужийн Арлингтон хотод төвтэй, дэлхийн 80 гаруй оронд 400 гаруй төсөл хэрэгжүүлсэн эдийн засгийн өөрчлөн байгуулалт, хувийн хэвшлийн хөгжил зэрэг чиглэлээр ажилладаг том компани юм.

Тус компаний эрдэмтэн судлаачид манай орны өрсөлдөх чадварын үзүүлэлтүүдийг 8 чиглэлээр гаргажээ. Эдгээр чиглэлийг дэлхий нийтээр өрсөлдөх чадварын шалтгаан, үр дагавар гэж үздэг.

Эдийн засгийн байдал: Нэг хүнд ногдох үйлдвэрлэл доогуур дөнгөж нэг тэрбум ам.долларын үндэсний нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Харьцуулсан 136 орноос 131-т бичигдсэн байна. Хууль бус хилийн наймаа, албан бус эдийн засгийн салбарын улмаас ҮНБ-ээ дугуу тооцдог. Гэсэн хэдий ч нэг хүнд 390 ам долларын ҮНБ ногддог нь мөнөөхөн 136 орноос 103 дахь байрт орсон байна. Монгол Улсын ҮНБ-ийн өсөлт 3,3%. Энэ нь 134 орноос 87 дугаарт явна гэсэн үг. Эдийн засгийнхаа өсөлтийнхөө хувьд дээрх орнуудаас хамгийн доогуурт оржээ.

Экспорт: Монгол улс 430 сая ам долларын бүтээгдэхүүн экспортлож, 186 орноос 133-т, нэг хүнд ногдох экспортын хэмжээ 143 ам доллар байгаа нь 176 орноос 130-д, экспортын бүтээгдэхүүн, үйлчилгээний хэмжээ нь ДНБ-ий 55% болж, 152 орноос 28 дугаар байрт орсон байна.

Хөрөнгө оруулалт: Дотоодын нийт хөрөнгө оруулалтын хэмжээгээр Монгол улс дэлхийн 136 орноос 59-д оржээ. ДНБ-д эзлэх гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээгээр 136 орноос 102-т, нэг хүнд ногдох хэмжээгээр 136 орноос мөн 102-т орсон байна.

Санхүүгийн салбар: Энэ салбарыг хөгжлийн хэмжүүрээр авч үзэхэд Монгол улс маш сул хөгжсөн банкны салбартай гэнэ. ДНБ-д эзлэх банкны салбарын дотоод зээлийн хэмжээгээр Монгол 133 орноос 113-т орсон байна. ДНБ-д нийт мөнгөний эзлэх хэмжээгээр 131 орноос 94-т оруулсан байна. Санхүүгийн эрсдэлийн хэмжээгээр 186 орноос 73-т орсон байна.

Бодлогын орчин: Энэ чиглэлээр улс орныг судалдаг дэлхийн хоёр том байгууллага болох “Өв сан” болон “Фразер институт”-ийн аль нь ч бодлогын орчноор хийсэн цогц судлагаандаа Монголыг байр эзлүүлсэнгүй. Юутай ч төсвийн алдагдал болон инфляцийн сүүлийн жилүүдийн мэдээ нь Монгол улсыг хамгийн сул хөгжилтэй орнуудын тоонд оруулж байна. Гэхдээ улс орны нээлттэй байдлыг ерөнхийд нь илтгэдэг. ДНБ-д худалдааны эзлэх хэмжээгээр Монгол улс ихээхэн нээлттэй эдийн засагтай орны тоонд орж байна.

Шинжлэх ухаан, технологи: Монгол улс 13 мянган орчим компьютертэй гэж Дэлхийн банкнаас 1997 онд гаргасан судалгаанд дурьджээ. Сүүлийн үед энэ тоо улмаар хоёр дахин өссөн гэж судлаачид үзжээ. 1997 оныхоор 103 орноос 72-т орж байв. Интернэтийн сүлжээнд холбогдсон байдлаар 146 орноос 106-т оржээ.

Шинээр технологийн экспортын хэмжээ, боловсруулсан бүтээгдэхүүний экспортын дөнгөж хоёр хувийг эзэлдэг гэж тэд тооцож байна. Энэ нь 94 орноос 84 дугаар байрт орсон гэсэн үг. харин нэг хүнд ногдох эрдэмтэн, инженерүүдийн тоогоор Монгол дэлхийн дунджаас дээгүүр оржээ. Энэ үзүүлэлтээр 75 орноос 37-т оров.

Дэд бүтэц: Дэд бүтцийн хөгжлийг ерөнхийдөө нэг хүнд ногдох эрчим хүч, тээвэр холбооны хүчин чадлаар хэмждэг. Нэг хүнд ногдох телефон утасны тоогоор 149 орноос 94-т оров. Өөрөөр хэлбэл, 1000 хүнд 37 телефон ногдож буй ажээ. Гэхдээ энэ үзүүлэлт дэлхий даяар хурдан тархаж буй гар утасны улмаас нэлээд хэлбэлзэлтэй гэнэ. АНУ-руу Монголоос ярих гурван минутын үнэ 108 орноос 95-т орж дэлхий дээр хамгийн үнэтэйд тооцогдож байна. Гэвч сүүлийн үед хямдарч байна.

Хүнийн нөөц, ажиллах хүч: НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хүний хөгжлийн индэксээр 174 орноос 119-т оров. Монгол хүний дундаж наслалт 66. Энэ үзүүлэлтээр 166 орноос 106-т орж байна. Нялхсын эндэгдлээр 148 орноос 99-д орсон байна. Монгол Улсын бичиг үсэгтгүй хүнгүй болж ЮНЕСКО-гийн шагнал хүртэж байсан цаг саяхан. Гэтэл саяын гаргасан судалгаагаар 143 орноос 75 дахь байранд оруулсан байна.

Монгол Улс зээл тусламжаас хараат байдлаар дэлхийд тавдугаар байранд явна. Энэ ангилалд дэлхийн улс орнуудаас эдийн засгийн сүйрэлд орсон, ойрын ирээдүйд хөгжих дэвжих чадавхи байхгүй, цаашид өөрөө өөрийгөө удирдаад аваад явна гэдэг ч эргэлзээ төрүүлдэг ядуу зүдүү нь багтдаг.

Мозамбек, Никарагуа, Молави, Лоас, Монгол зэрэг орнуудын үндэсний нийт бүтээгдэхүүнд хөгжлийн албан ёсны тусламжийн эзлэх хувийн жин 20,6-68,2 хувьд хүрсэн гэсэн судалгаа гарчээ. Эднийг баян орнуудын албан ёсны гуйлгачингууд гэж нэрлэж, ард түмэн нь бол туслахаас ихэвчилэн дургүйцдэг.

Энэ тухай НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн судалгааны ажлын хэсгийн ахлагч, Калифорнийн их сургуулийн хүндэт профессор Кит Гриффин ингэж дүгнэжээ.

Хандивлагчдын туслая гэдэг санаа мэдээж сайхан ч зээл тусламжийн авчирсан үр нөлөө нь сүйрлийн дайтай байна. Гадаадын зээл тусламж дотоодын шинэчлэлд саад үүсгэж, төрийн эдийн засгийг удирдан шилжилтийн үеийг давах хүчин чадлыг сааруулжээ. Нэг хүнд ногдох орлого 1995 онд 4,7%-тай байснаа, буурсаар 2000 онд сөрөг үзүүлэлттэй болж 2001 онд тэгийн орчим байхаар тооцоологджээ. /2002 онд 3 орчим хувь гэж байгаа нь эргэлзээтэй/

Монгол Улс хөгжихийн тулд биш хэрэглээгээ хангахын тулд л их зээл авч байна. Энэ бол аюултай стратеги гэж Терри Макинли /АНУ/ бичжээ. Энэ эрдэмтэн Монголын эдийн засагт дүн шинжилгээ хийгээд, засгийн газарт доорхи зүйлийг анхааруулжээ.

Монгол улс өнөөдөр тэрбум шахуу ам.долларын зээлтэй. Монгол Улс энэ зээлийг эргүүлж төлөх шаардлагатай тулгарч л таарна. Хэрвээ эдийн засгийн өсөлт, экспортын үйлдвэрлэл өнөөгийн байдалдаа хэвээр байх юм бол зээлийг буцаан төлөх нь туйлын хүнд бөгөөд тэр цагт улс орны хувь заяа, сүүлийн арван жилийн дотор томоохон зээлийг өгсөн Азийн хөгжлийн банк /нийт зээлийн 32%/ Япон улс /нийт зээлийн 21%/ Герман, ОХУ, Хятад Норвеги /нийлээд нийт зээлийн 12% арилжааны зээлийн 20 орчим хувийг эзэлсэн/ хандивалагчдын гарт орох нь байна.

Өөрөөр хэлбэл, сүүлийн арав гаруйхан жилийн дотор Өрнийн ертөнц Монгол оронд бараг хоёр тэрбум доллараа зарцуулжээ. Дэлхий дахины ДНБ болох 30 триллон доллар, эсвэл АНУ-ын батлан хамгаалах зардалд жилд гардаг 350 тэрбум доллар, эсвэл хөгжиж буй орнуудад жилд үзүүлдэг Японы тусламж болох 10 тэрбум доллартай харьцуулахад энэ нь бага л даа. Харин хүн амтай нь харьцуулахад энэ нь аврага тоо гарна. Ухаан нь энэ хооронд Индонез улс 200 тэрбум доллар авчихлаа гэсэн үг болно. Гэтэл Индонез нь нэг хүндээ 6 доллар буюу арав гаруй жилд 15 хүрэхгүй тэрбум долларын тусламж авчээ.

Хэдийгээр хандивлагчид зээлийнхээ тал хувийг хэрэгсэхгүй болгосон ч Монгол Улс, ер яваандаа хүчингүй болдог гэсэн үзэл бодолд тулгуурлан бодлогоо боловсруулж болохгүй хэмээн ноён Терри Макинли дахин анхааруулжээ.

Америкчуудын Монголын талаар хийсэн томоохон цар хүрээтэй бас нэгэн судалгаа өнгөрсөн онд гарлаа. Судалгааны нэгтгэсэн дүнг “Соросын сан” нэрээр хязгаарлагдмал хүрээнд тараасан байна. Энэ нь нэлээд олон жилийн хүн хүч, хөрөнгө мөнгө шаардсан буурьтай судалгаа. Үүнд: Монгол улсын өнөөгийн нийгэм, улс төр, эдийн засаг, хүний хүчин зүйл, гадаад харилцаа, социолги, нийгмийн сэтгэл зүйн байдлыг сүрхий оновчтой, далайцтай судлаж ойрын ирээдүйн дүр зургийг гаргаж ирсэн байна. Мэргэжлийн маш олон хүрээ судалгаанд дайчлагдсан нь ч тодорхой харагдаж байна.

Аливаа судалгаа тэс хөндлөн хийгдсэн байх тусмаа илүү үнэтэй байдаг гэдгийг энд давтан хэлэхийг хүсч байна. Тэр чанараараа энэ судалгаа нэлээд бодитой, бодитойгийн хэрээр ноцтой, түгшүүртэй бүтээл болжээ. Мэдээж, монголчуудын хувьд шүү дээ, түүнээс хөндлөнгийн судлаачид Монголын хувь заяа хаашаа эргэх төлөвтэй байгаа нь ямар пад байх билээ. Түгшүүртэй гэдгийн учир нь одоогийн нөхцөл, ирээдүйн төлөв хар бараан талдаа гарсан байна.

Олон улсын тавцан дээр Орос, Хятадаас өөр газрын сонирхол татахуйц газар зүйн болоод геополитикийн байрлал үгүй, гадаадын хөрөнгө оруулалт татахуйц эрдэс баялаг, зах зээл үгүй, төр засаг авилгалд идэгдсэн, төрийн бүтэц тогтоц нь оновчтой биш, улс төрийн намуудын аль нь ч төлөвшөөгүй, байгаль цаг уурын сүйрлийн ирмэгт тулсан, уул уурхайн олигтой нөөц одоо болтол илрээгүй /Оюу толгойн зэс, алтны ордыг эс тооцвол-зохиогч/, дэндүү бага зах зээлтэй, тархины зугтаалт эрчимтэй болж байгаа /боловсролтой нь гадагш дүрвэж байна/, улс даяар өрнөж буй нүүдлийг зохицуулсан бодлого үгүй, засаг захиргааны нэгжийн бүтэц нь оновчгүй учир маш үрэлгэн, хуулийн орчин бүрэлдээгүй, нийгмийн дотор хөрөнгийн хувьд баян ядуу, сэтгэлгээний хувьд залуу хөгшин, оюуны хувьд боловсролтой харанхуй, соёлын хувьд хот хөдөөний гэсэн ялгаа нь өдөр өнгөрөх тутам улам ялгаран холдсон, хүн амын дийлэнхи нь өнөөгийн дэлхий дахины глобалчлагдаж буй бодит фактын эсрэг сэтгэлгээтэй, өөрөө хэлбэл гадагш дайсагнасан, үл итгэсэн хандлагатай, хүмүүс нь бизнесийн сэтгэлгээгүй буюу дутмаг, итгэл даах итгэлцүүр ядмаг, сэхээтэн болон

мэргэжилтнийх нь ур чадвар өрсөлдөх чадвар дорой гэх мэт дэндүү бараан үзүүлэлтүүд гарчээ.

Монголчууд бид энэ талаар дээр доргүй бодох цаг болжээ. Нэг үгээр хэлбэл сүйрлийн ирмэгт тулж ирээд сүйрэл биднийг хаман авч одооор хаалга тогшиж байна.

Монголчууд бид Япон, Солонгосчууд шиг улс оронд нь хүнд цаг үе тохиолдсон үед зангидсан гар шиг нэгдэн нягтарч, өөрийгөө, өөрт байгаагаа улсдаа зориулдаг тийм сайхан чанар дутагдаж байна. Одоо бид энэ хүнд шалгуурын өмнө тулж ирээд байна. Нөгөө талаар өрнөдийнхэн Монголыг глобалчлалын талбар руу хэдий чинээ сайн түлхэнэ Монголын эдийн засаг төдий чинээ хурдан хөгжих болно.

Монгол орны дүр төрх ийнхүү ерөнхийдөө бараан талдаа байгаа хэдий ч бас ч гэж боломжийн нааштай хүчин зүйлс байгааг энд тэмдэглэн хэлэх нь зүйд нийцэх бизээ.

Улс орнуудын хөгжил, эдийн засгийн байдалд үнэлгээ өгдөг дэлхийн хамгийн том байгууллагын нэг “Standart and Poor’s” компани 2002 оны 3-р сард Монгол Улсын зэрэглэлийг тогтоосон. Монгол Улс 1999 онд С үнэлгээгээр эхэлж, одоо В⁺ зэрэглэлтэй болжээ. Олон улсын жишиг хэмжүүрээр үзэхэд Монголд бага ч гэсэн ахиц өөрчлөлт гарч байгааг харуулж байна.

Хөгжингүй гүрнүүд саарыг нь шахаж, сайныг нь дэмжих замаар Монгол Улсыг глобалчлалын талбар руу хэдий чинээ сайн түлхвэл төдий чинээ хурдан хөгжих боломж бий.

ИШЛЭЛ

1. Эх сурвалж: Монгол улсын засгийн газар, 2003 онд нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл 2004-2006 онд хөгжлийн чиг хандлага
2. Хэрэглээний үнийн жилийн дундаж индексийн өөрчлөлт